



ИРГЭДИЙН АНХААРАЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ 5 ДУГААР САРЫН 13-НИЙ ӨДРИЙН 170 ДУГААР ТОГТООЛООР ИРГЭНД 2020 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД ИРГЭДЭД ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТЫГ ХЭЛЭЛЦЭН БАТАЛСАН.

ИРГЭДЭД ӨМЧЛҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ ГАЗАР НЬ НИЙГМИЙН БОЛОН ДЭД БҮТЭЦ, ХУДАГ УС, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭРТЭЙ ГАЗАРТ ИРГЭДЭД ӨМЧЛҮҮЛЖ БАЙХААР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙНА.

ИЙМД ИРГЭДЭЭС 2020 ОНД ШИНЭЭР ГАЗАР ӨМЧЛӨХ ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХГҮЙ БОЛОХЫГ МЭДЭГДЬЕ.



ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

70546271, 88012061



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 5 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар
хот

Иргэнд 2020 онд өмчлүүлэх газрын нийт
хэмжээ, байршил, зориулалтыг
тогтоох тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасныг
үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг үндэслэн
2020 онд иргэнд өмчлүүлэх одоо эзэмшиж байгаа газрын нийт хэмжээ, байршил,
зориулалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот
байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Барилга, хот байгуулалтын сайд

Х.БАДЕЛХАН

Засгийн газрын 2020 оны 170 дугаар
тогтоолын хавсралт

ИРГЭНД 2020 ОНД ӨМЧЛҮҮЛЭХ ОДОО ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН
НИЙТ ХЭМЖЭЭ, БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ

№	Аймаг	Өмчлүүлэх газрын байршил	Одоо эзэмшиж байгаа өмчлүүлэх газрын нийт хэмжээ
1.	Архангай	сум, багийн төв	186.88
2.	Баян-Өлгий		137.5
3.	Баянхонгор		-
4.	Булган		25.92
5.	Говь-Алтай		11.66
6.	Говь-Сүмбэр		3.5
7.	Дархан-Уул		42.42
8.	Дорноговь		4.8
9.	Дорнод		6.8
10.	Дундговь		2.33
11.	Завхан		30.83
12.	Орхон		8.9
13.	Өвөрхангай		12.96
14.	Өмнөговь		0.8
15.	Сүхбаатар		19.57
16.	Сэлэнгэ		75.66
17.	Төв		79.73
18.	Увс		36.16
19.	Ховд		33.8
20.	Хөвсгөл		65.08
21.	Хэнтий		31.42
22.	Нийслэл	дүүрэг	119.41
Нийт дүн			936.14